

**“СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИЙГ БАРИВЧЛАХ, ЦАГДАН ХОРИХОД ШҮҮГЧЭЭС АНХААРАХ
 ЗАРИМ АСУУДАЛ” ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТИЙГ 2002-09-01- НЭЭС 2002-12-15-НЫГ
 ХҮРТЭЛ ХУГАЦААНД СУДАЛСАН ДҮНГИЙН ТУХАЙ ТОЙМ**

2003.03.05

Улаанбаатар хот

Монгол Улсын ЭБШХуулийг 2002 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөнтэй холбогдуулан сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих зөвшөөрлийг шүүгч олгох болсон билээ. Үүнтэй холбогдуулан Улсын Дээд шүүхийн хуралдаанаар “Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хориход шүүгчээс анхаарах зарим асуудал” гэсэн зөвлөмжийг гарган нийт шүүхүүдэд хүргүүлж ажилласнаас хойш тодорхой хугацаа өнгөрөв.

Эрүүгийн байцаан шийтгэх шинэ хууль хэрэгжиж эхэлсэн 2002-09-01-нээс 2002-12-15-ныг хүртэл хугацаанд Улсын Дээд шүүхээс гаргасан зөвлөмжийн биелэлт хэрхэн хэрэгжиж байгаа болон ямар бэрхшээлтэй асуудлууд тулгарч байгаа талаар бүх шүүхүүдээс авсан дүн мэдээг нэгтгэн судлав.

Дээрхи хугацаанд улсын хэмжээгээр нийт 1685 сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих зөвшөөрөл олгосныг аймаг, нийслэл, дүүргээр нь үзүүлбэл:

Д/д	Шүүхийн нэр	Шүүгчийн нэр	Баривчилсан хүний тоо	Цагдан хорьсон хүний тоо	Баривчлах, хорихоос татгалзсан буюу өөрчилж, хүчингүй болгосон хүний тоо
1	Архангай	М.Жаргалсайхан Р.Алтанцэцэг		28	7
2	Баян-Өлгий	Х.Жардемхан		56	7
3	Булган	С.Цэрэндулам	15	13	1
4	Баянхонгор	Б.Гэрэлмаа	49	39	3
5	Говь-Алтай	Д.Мөнхтуяа	5	32	
6	Говьсүмбэр				
7	Дархан-Уул	Б.Сувдаа		89	14
8	Дорнод	П.Мөнхтөр	25	41	2
9	Дорноговь	Н.Батчимэг Б.Цэнд	12	31	
10	Дундговь	Л.Банзрагч	3	10	5
11	Завхан	Б.Оюунцэцэг Д.Мөнхөө Ц.Баасанжав		20	
12	Өвөрхангай	Р.Шүрхүү Ч.Баасанжав	2	35	5
13	Өмнөговь	Д.Цаян	8	20	9
14	Сэлэнгэ	С.Норолхоосүрэн Д.Мөнхцэцэг Ч.Алтанцэцэг Г.Сарантуяа	15	67	2
15	Сүхбаатар	Ш.Оюунгэрэл		29	3
16	Төв	Л.Мөнхцэцэг С.Оролмаа	64	131	33
17	Увс	Ч.Элдэв-Очир	7	73	12
18	Хөвсгөл	Н.Нямсүрэн Б.Сосорбарам	4	33	6
19	Ховд	Б.Бямбасүрэн		19	

		Б.Бадрахгэрэл			
20	Хэнтий				
21	Орхон	Э.Ариунаа Д.Энхбаяр	6	48	4
22	Нийслэл		239	966	
	Багануур	Д.Оюунбат	4	13	3
		С.Оюунгэрэл			
	Баянзүрх	Н.Сүхбаатар	58	157	
	Налайх	Л.Энхбилэг	7	36	
	Сонгинохайрхан	Д.Завуд Б.Оюун	28	74	
	Сүхбаатар	Ч.Тунгалаг		100	
	Хан-Уул	Л.Оюунчимэг			
	Чингэлтэй				
	Баянгол				

Харин Говьсүмбэр, Хэнтий аймаг, Чингэлтэй, Баянгол дүүргийн шүүхүүд судалгаанд хамрагдаж, мэдээгээ хугацаанд нь ирүүлээгүй тул дүгнэлт хийх боломжгүй байна.

Судалгаанаас үзэхэд ихэнхи аймгийн шүүх, прокурор, цагдаагийн байгууллагууд сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих асуудлыг хуульд заасан журмын дагуу шийдвэрлэхэд бэрхшээлтэй, тулгамдсан асуудлууд харьцангуй цөөн гарч байна гэжээ. Шүүхээс цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хүнд, онц хүнд гэмт хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, удаа дараа ял шийтгүүлсэн этгээд, өмнө нь авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн этгээд, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлж болзошгүй, эсхүл оргон зайлсан, хэргийн бодит байдлыг тогтооход саад учруулж болзошгүй этгээдүүдэд голчлон хэрэглэсэн байна. Харин хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэгт сэжиглэгдсэн болон, насанд хүрээгүй этгээдэд ЭБШХ-ийн 68 дугаар зүйлийн 68.2-т заасан үндэслэл байгаа тохиолдолд сэжигтнээр 14 хоногоос илүү хугацаагаар цагдан хорихгүй байх зарчмыг баримталсан байна.

Зарим аймгийн шүүх, тухайлбал Дорнод, Завхан аймгийн шүүх урьдчилан хорих байранд хоригдож буй хүмүүсийг тогтоолтой нь тулган шалгах, хоригдогсдын санал хүсэлтийг сонсох, Хан-Уул дүүргийн шүүх сэжигтнийг баривчлах, цагдан хорих хугацааг сунгахдаа хуулийн хугацааг чанд баримтлах үүднээс “яллагдагчийг хорьж мөрдөх хугацаанд хяналт тавих карт”-ыг хөтлөн хяналт тавьдаг бөгөөд хорьж мөрдөх хугацааг хэтрүүлэн тогтоолгүйгээр хорьсон зөрчил гаргасан тохиолдолд хугацаа хэтрүүлэн хоригдсон яллагдагчийн цагдан хорих хугацааг сунгахдаа татгалзах, мөрдөн байцаагчид нь арга хэмжээ авахуулах зэргээр хууль зөрчсөн дутагдлыг арилгуулах арга хэмжээ авчээ.

Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд зарим төрлийн зөрчил дутагдал нийтлэг байна. Тухайлбал:

1.-Сэжигтнийг баривчлах, сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх, сунгуулах тогтоолын маягт хуулийн шаардлага хангахгүй, тогтоолын маягтанд хэрэг бүртгэх алба, мөрдөн байцаах албаны дарга “зөвшөөрөл” өгөхөөр хэвлэгдсэнээс хэрэг бүртгэх, мөрдөн байцаах албаны дарга гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж хуулиар олгогдоогүй эрхийг эдэлж байгаа,

2.-Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорууд цагдан хорих хугацааг хугацаанд нь сунгуулахгүй байх, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг шүүгчид мэдэгдэхгүй өөрчлөх, цагдан хорих зайлшгүй шаардлагатайг нотолсон баримт хангалттай биш байх, тогтоолд сэжигтнээр холбогдсон хэргийн зүйлчлэлийг бичихгүй байх, сэжигтэн, яллагдагчаар гарын үсэг зуруулахгүй байх, баривчилсан, цагдан хорьсон цаг хугацааг тодорхой бичихгүй орхих, сэжигтнээр баривчилсан этгээдийн асуудлыг цаашид хэрхэн шийдвэрлэсэнээ эргэж мэдэгдэхгүй байх,

3.-Хөдөө орон нутагт өөр өөр аймаг, сумдад оршин суудаг хүмүүс хамтран гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд тэдний нэр, хаягийг иргэний үнэмлэх, бичиг баримтгүйн улмаас үнэн зөв тогтоох боломжгүй байх, тухайн орон нутагт байх тодорхой хаяггүй, батлан даалтад өгөх бусад таслан сэргийлэх арга хэмжээ авахад хүндрэл учрах, хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэгт

холбогдсон зарим хүмүүс батлан даагч олдохгүй байхгүйгаас цагдан хорих арга хэмжээ авах, улмаар хорьж мөрдөх хугацааг сунгаж байгаа,

4.-Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар заавал цагдан хорьж мөрдөх гэсэн хуучинсаг арга барилаасаа салахгүй, тогтоолд зориуд хүнд ялтай зүйл заалтыг бичиж ирэх,

5.-Сэжигтнээр цагдан хорих 14 хоногийг хуульд сунгаж болох эсэх талаар тодорхой зохицуулалт байхгүйгээс шүүх, прокурор, цагдаагийн байгууллагын хооронд санал зөрөх,

6.-Шүүгч тогтоолыг батлахаас өмнө сэжигтнийг баривчилсан зөрчил их гарч байгаа.

7.-Шүүгчид цагдан хорих хугацааг сунгах эсэхийг 72 цагийн дотор хянах боломжийг олгохгүй байх,

8.-Сэжигтэн болон яллагдагчийг цагдан хорих тогтоолыг прокурор хэргийн хамт шүүхэд танилцуулах ёстой байхад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар өөрсдөө танилцуулах гэж ажилд саад учруулах, прокурор, мөрдөн байцаагч нар сэжигтнээр баривчлах үндэслэлээ тодорхой заахгүйгээр, зөвхөн оргон зайлж болзошгүй, оршин суух хаяг тодорхойгүй гэсэн шалтгаан зааж цагдан хорихыг шаардах,

9.-Эзэнгүй хэргийн сэжигтэн, яллагдагчийг баривлах, цагдан хорих асуудал болон гүйцэтгэх ажлын шугамаар цагдан хорих зөвшөөрөл олгох эсэх нь хуульд тодорхой тусгагдаагүй,

10.-ЭБШХ-ийн 69.5-д “Мөрдөн байцаагч хорьж мөрдөх хугацааг сунгах тухай үндэслэл бүхий тогтоол үйлдэж хугацаа дуусахаас 7 хоногийн өмнө прокурорт хүргүүлэх бөгөөд прокурор шүүхэд хүргүүлнэ” гэж заасан байхад 7 хоногийн өмнө биш хорьж мөрдөх хугацаа дууссаны дараа хугацаа сунгуулахаар шаардах,

11.-шүүгч тогтоолыг хүлээн авсан өдрөөр баталдаг, хугацаа алдсан үеийн хариуцлагыг хэн хүлээх,

13.-хэрэг нь шүүхээр шийдвэрлэгдэн ялаа эдэлж байх хугацаанд уг хэрэг дээд шатны шүүхэд хянагдан тогтоол нь хүчингүй болж дахин мөрдөн байцаалтанд буцсан, урьд нь 24 сар цагдан хоригдсон тохиолдолд уг хугацааг яаж тооцох нь тодорхойгүй байгаа зэрэг бэрхшээл, зөрчил байгаа талаар төв орон нутгийн шүүхүүдээс ирүүлсэн илтгэх хуудсанд дурьдсан байна.

Тэднээс ирүүлсэн санал хүсэлтийг судлаж үзэхэд ЭБШХуулийн заалтыг өөрчлөх буюу УДШ-ийн тайлбар гаргах зайлшгүй шаардлага гараагүй байх бөгөөд харин хуулийн заалтыг нэг мөр ойлгож хэрэгжүүлж чадахгүй байгаа, ажил хариуцсан хүмүүсийн хамтын ажиллагаа, харилцан ойлголцох явдал дутмаг, хувь хүмүүсийн мэдлэг чадвар, ажлын арга барил, дадлага туршлагаас шалтгаалсан бэрхшээлүүд байна гэж үзэв.

Иймд цаашид дараах чиглэлийг баримтлан ажиллах шаардлагатай байна.

1.Баривчлах, цагдан хорих зөвшөөрөл олгохтой холбогдсон Эрүүгийн Байцаан Шийтгэх хуулийн зүйл, заалтуудыг ягштал мөрдөж, уг асуудалтай холбоотой хуулийн, онолын болон албан ёсны тайлбар, зөвлөмжийг сайтар судлах.

2.Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нарын хамтарсан сургалт, семинарыг тодорхой сэдвээр орон нутагтаа зохион байгуулж байх.

3.ЭБШХ-ийн заалт зөрчсөн, хуулийн шаардлага биелүүлдэггүй хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокуроруудын үйл ажиллагааны талаар дээд шатны удирдлагад нь мэдэгдэж хариуцлага тооцдог болох.

4.2002 оны жилийн эцсийн мэдээний /маягт ШС-10/ нэгдсэн дүнгээс үзэхэд зарим аймгийн шүүхүүд нэг ч удаа баривчлах зөвшөөрөл олгоогүй нь үнэмшил багатай байгааг анхаарч бүртгэл судалгааг үнэн зөв гаргаж, мэдээ тайланг цаг хугацаанд нь ирүүлж байх.

5.Хуулийн заалтыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан орон нутагт журамлан зохион байгуулж болохуйц асуудлын талаар өөрсдийн эрх хэмжээний болон хуулийн хүрээнд тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

6.Аймаг, Нийслэл, сум буюу сум дундын шүүх болон дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч баривчлах, цагдан хорих зөвшөөрөл олгодог шүүгч нарын ажлыг тусгайлан шалган, тусалж ажил мэргэжлийн удирдлагаар тогтмол хангаж байх.

УДШ-ИЙН ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАНХИМ ШҮҮХИЙН СУДАЛГААНЫ ТӨВ